



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 сны 03 сарын 24 өдөр

Дугаар А/23

Чойр

Эд хөрөнгө устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.1, Байгууллагын өмч хамгаалах комиссын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар хуралдааны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хангамжийн материалын дансанд бүртгэлтэй зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон 10 000 000 төгрөгийн 1539 боодол өвс, нэг бүр нь 80 000 төгрөгийн үнэтэй 5 ширхэг хяналтын камер нийт 10 400 000 /арван сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн хөрөнгийг Байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлтийг үндэслэн актлахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга

Г.Хонгор (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга

В.Баярсайхан (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны менежер)

Гишүүн

Т.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)

3. Эд хөрөнгийг устгах ажлыг хууль, журамд заасны дагуу гүйцэтгэж, тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Г.Хонгор/-т даалгасугай.

ДАРГА



Д.СОДНОМ